МОНГОЛ ЭМЧ, МААРАМБУУДЫН ХЯТАД, МАНЖ, ТӨВӨД, ОРОС, МОНГОЛ ХЭЛЭЭР БИЧСЭН, ЭДГЭЭР ХЭЛНЭЭС ОРЧУУЛСАН ЭРТНИЙ СУДАР НОМ, СОЁЛЫН БИЕТ БУС ӨВ

Ш.Болд[1], Б.Гэрэлмаа[2], Г.Сумъяахорол[2], Х.Улаан-Од[2], Д.Шагдарсүрэн[3]
[1]МАУА, [2]"Ач" АУИС, [3]ЭЗШУИС,
E-mail: boldshrv@gmail.com

Abstract

ANCIENT MEDICAL BOOKS TRANSLATED FROM CHINESE, MANCHU, TIBETAN, RUSSIAN, AND WRITTEN IN MONGOLIAN LANGUAGES BY MONGOLIAN DOCTORS AND INTANGIBLE CULTURAL HERITAGE

Bold.Sh[1], Gerelmaa.B[2], Sumyakhorol.G[2], Ulaan-Od.Kh[2], Shagdarsuren.D[3]
[1]Mongolian Academy of Medical Sciences, [2]"Ach" Medical University,
[3]Mongolian University of Pharmaceutical Sciences
E-mail: boldshrv@gmail.com

Currently, around 20 doctors have received doctoral degrees and 100 doctors have received a master's degree for research in sources directly related to the 5,000-year history of Mongolian medicine, including theory, philosophy, clinic, and medicine found in the past 30 years. In the future, the history of Mongolian medicine can go back from 5000 years to 6000 years. However, history requires facts, thus it is essential to seek and explore evidence in ancient medical scriptures written in Chinese, Tibetan, Manchu, and Mongolian languages, as well as archeological findings related to medicine.

One of the main areas of research in the history and sources of medical science is to examine the reality, nature, and stages of development of the main concepts of knowledge on fighting diseases, the contribution of doctors and scientists to it, and the importance of scriptures and treatises. Since ancient times, Mongolians have created methods to adapt to the transformation of natural phenomena, extreme climate changes, the characteristics of life, habits, and treatment of injuries and diseases caused by war, developing and creating an independent system of healthy living methods. This system was not only based on the knowledge of Mongolian dhom, Indian and Tibetan medicine, but it was also a complex of knowledge that absorbed the ancient scriptures of French and Russian medicine with the classical tradition of Western medicine as well as Manchu and Chinese medicine. Therefore, we believe that some of the traditional medicine methods in the 215 sutras should be registered as intangible cultural heritage.

Keywords: history, Mongolian medicine, medical scriptures, sutras, Mongolian doctors

Оршил


Бидний олон жилийн хөдөлмөр шингэсэн, өнгөрсөн 30 орчим жилийн хугацаанд хийсэн судалгааны ажлын үр дүнд Монголын уламжлалт анагаах ухаан 5000 жилийн түүхтэй гэдгийг тогтоосон [1,2]. Хамгийн анх шинэ чулуун зэвсгийн гурав дахь мянган жилд анагаах ухаанд хэрэглэж байсан багаж хэрэгсэл олдсоноос үүдээд үүнийг давхар батласан Төвөдийн засаг баригч Дэсрид Санжаажамц гэж хүний түүхийн ном бий [3]. Төвөд хэлнээс англиар "History of Tibetan Medicine" гэсэн нэрээр орчуулагдсан энэ ном бол Монголын анагаах ухааны шинэ чулуун зэвсгийн үед хэрэглэж байсан чулуун зүүг хэрхэн хэрэглэж байсан талаар, хичнээн арга байсан талаар тодорхой дурдсан, тэр нь монголчуудын арга гэж тэмдэглэсэн баримт дээр тулгуурлан Монголын анагаах ухаан 5000 жилийн түүхтэй гэж үзэх бүрэн үндэстэй юм [3]. Энэ 5000 жилийн хугацаанд олдсон эх сурвалжууд түүний дотор онол, гүн ухаан, эмнэлзүй, эмийн чиглэлээр одоогоор 10 орчим эмч докторын, 60 орчим эмч магистрын зэрэг хамгаалсан. Цаашид Монголын анагаах ухааны түүх 5000 жилээс урагшлан 6000 жил рүү ч ахиж болно. Гэхдээ түүх бол өөрөө заавал баримт, факт шаарддаг, тийм учраас баримт

нотолгоог хятад, төвөд, манж, монгол хэлээр бичсэн анагаах ухааны эртний судар ном, анагаах ухаантай холбоотой археологийн олдворуудыг эрж хайх нь нэн чухал болой.

Үр дүн

Тойн Жамбалдоржийн “Үзэсгэлэнт нүдэн чимэг” гэж монгол хүний бичсэн сайхан бүтээл буй. Бүтээлийн дотор орсон 870 гаруй ургамал, амьтны болон эрдсийн гаралтай түүхий эдийг монгол лам нар гараараа, өнгөтөөр зураад үлдээсэн ганц хувь судар байна. Түүнчлэн Хубилай сэцэн хааны ордны зоогийг хамаарч байсан эмч нарын бичсэн тэмдэглэлийг нэгтгээд, Хүсэхүй гэдэг монгол хүн 1330 онд хятад хэлээр бичсэн зохиолын Мин улсын хэвлэл бидэнд олдсон. Юань улсын хэвлэл нь олдохгүй байна. “Ge ti ciowan lu bithe” гэж манж хэлээр бичсэн анагаах ухааны найман дэвтэр зохиол бий. Энэ ном манай Үндэсний номын санд байхгүй, одоо Францын түүхийн хүрээлэнгийн архивт ганцхан хувь хадгалагдаж байгаа. Тод үсгээр бичсэн “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн орчуулга, монгол бичгээр, төвөд үсгээр монголчуудын бичсэн тайлбар гээд олон ном байна. Энэ олсон судруудаа дотор нь задлая.


1. Хятад хэлээр бичсэн, орчуулсан судар гурав байна. Гэхдээ монгол хүний бичсэн судар ч бий, хятадын эртний алдартай судрыг монголчууд орчуулсан ч байгаа. Шатмөс гэдэг монгол хүний 14 дүгээр зууны үед хятад хэлээр бичсэн Хятадын анагаах ухааны “Билигт хулсан тэнхимийн туслах жор” гэж гайхалтай ном байгаа. 1601 онд Мин улсын үед бичсэн “Zhenjiu Dacheng” (Хатгах төөнөх тэргүүтнийг их хураасан ном дэвтэр) гэдэг номыг монголчууд тод үсгээр орчуулж гар бичмэлээр хадгалж байв. Хятадын анагаах ухааны зүүний хамгийн сонгодог бүтээл. Энэ бүтээлийг Б.Ринчен гуай 1967 онд гэрэл зургаар татаж үлдээсэн [4]. Энэ ном бол 18 зууны хоёрдугаар хагаст тод үсгээр орчуулагдсан. Нийт 10 дэвтрийг бүгдийг нь тод үсгээр орчуулсан боловч харамсалтай нь үрэгдээд 4, 6-р дэвтэр нь үлдсэнийг Ринчен гуай хоёр дэвтэр болгоод гаргасан. Тэгэхээр 4, 6 нь байна гэдэг нь 10 дэвтрийг бүгдийг нь орчуулсан гэсэн үг юм. Харамсалтай нь гар бичмэлээр ганцхан хувь, Увс аймгаас олдсон.



Зураг 1. Монгол хүний хятад хэлээр бичсэн болон орчуулсан зохиолууд

2. Манж хэлээр бичсэн, орчуулсан эртний ном судар одоогоор бидэнд тав байна. Манж хэлээр бичсэн, гэхдээ Үндэсний номын санд болоод бусад номын санд бараг байхгүй байх. Манж хэлээр бичсэн энэ гурван зохиол нэг гаралтай, дотроо өөр өөр байдлаар сэдэвчилснээрээ ялгаатай [5]. Таван манж номын гурван номын нэг нь 6 дэвтэр, нэг нь 8 дэвтэр, нөгөөх нь 1 дэвтэр буй.

Бас нэг хувилбар нь зургаан дэвтэр, монгол орчуулга нь зургаан дэвтэр гэх мэтчилэн дэвтрээр нь тоолох юм бол 23 дэвтэр олдоод байна [6]. Бидний хийсэн судалгаагаар дэлхий дахинд Ленинград, Бээжингийн номын сан, Копенгагений номын сан, Франц, Японы номын санд хадгалагдаж байгаа манж хэлээр бичсэн 31 зохиол байна. Энэ тоо цаашаа нэмэгдэх бололцоотой.



Зураг 2. Манж хэлээр бичсэн зохиол түүний монгол оруулга

3. Төвөд хэлээр бичсэн зохиол мэдээж гол байрыг эзэлнэ. Яагаад гэвэл монголчууд бурхны шашны үндсэн их таван ухааны нэгийг маш сайн хөгжүүлж, Энэтхэгээс уламжилж Төвөдөд синтез хийгдээд Монголд дэлгэрсэн энэ гайхалтай бүтээлүүд төвөд хэлээр бичигдсэн. Одоогоор 150 зохиол байгаа.




Зураг 3. Төвөд хэлээр монгол лам, эмч нарын бичсэн эмийн судрууд

Гэхдээ энэ 150 зохиол бол зөвхөн монгол хүний төвөд хэлээр бичсэн, эсвэл орчуулсан зохиол. Тэгэхлээр бидний өвөг дээдэс маш их, үнэт өвийг бидэнд үлдээсэн байна. Монгол данжуур дотор байгаа 7 зохиол, нарийн тоолбол эмийн нэрсийн жижиг номыг нэмэх юм бол үндсэндээ найман зохиол болно. Энэ найм бол төвөд анагаах ухааны зохиол биш юм. Эртний Энэтхэгийн аюурведийн анагаах ухаан, ялангуяа Аюурведийн их гурвал гэж алдартай зохиол бий. Ингээд нийтдээ 150 зохиол болж байна.

4. Эртний орос хэлнээс орчуулсан номууд цөөн боловч байна. 1811 онд Ойрадууд, ялангуяа Халимагуудад зориулж орос хүн оросоос халимаг хэлээр тод үсгээр орчуулсан зохиол юм [7]. Монгол Улсын Үндэсний номын санд ганцхан хувь хадгалагдаж байна. Бид энэ номыг орчин цагийн кирилл үсгэнд буулгаад 240 орчим үгийн тайлбар хийгээд удахгүй хэвлэх гэж байна.

5. Монгол хэлээр бичсэн эртний домын цөөнгүй судар байна. Бидэнд 30 судар хадгалагдаж байна. БНХАУ-ын Өвөр Монголд хадгалагдаж байгааг нэмэх юм бол нэмэгдэх бололцоотой.



Зураг 4. Хар домын судрын дээж

Нийтдээ 13-20 дугаар зууны хугацаанд хятад, манж, төвөд, орос, монгол хэлээр бичсэн орчуулсан эртний судар ном яг 215 байна. Мэдээж өөр эртний эдлэл цуглуулдаг ч юм уу, судар ном сонирхдог улсуудад давтагдахаас гадна бидэнд байхгүй бүтээлүүд байж болох юм.

Төвөд хэлээр монгол эмч, маарамба нарын бичсэн эртний 150 зохиолыг дотор нь ангилаад үзвэл уламжлалт анагаах ухааны эмч нарын үздэг үндсэн шүнгийн ном буюу гол итгэмжит ном “Анагаах ухааны дөрвөн үндэс”-тэй холбоотой монголчуудын бичсэн, орчуулсан, тайлбар хийсэн 81 зохиол байна. Эмийн түүхий эдийн судлалтай холбоотой 11, эм найрлагын судлалтай холбоотой 5, анагаах ухааны түүхтэй холбоотой 2, онол гүн ухааны судлалтай холбоотой судар 5, таван заслын судар 8, эмчилгээ заслын судар 21, малын өвчний заслын судар 9, эмчийн сургуулийн жаяг, маарамбын дамжаа, эмийн зан үйлтэй холбоотой судар 6, эмийн ёгт нэрийн тайлбар 2, Монгол данжуурт байгаа аюурведийн зохиол найм, ингээд нийтдээ 158 зохиол байна. Хамгийн том судар нь бараг 700 орчим хуудастай, хамгийн бага нь 1-2 хуудастай судар буй.

Жишээ нь: Хүдрийн заарыг орлуулан хэрэглэдэг аргыг дурдсан 1 хуудастай, гараар бичсэн судар байна. Хүдрийн заар гэдэг тэр ховор амьтны заарыг нь заавал амийг нь егүүтгэхгүйгээр ургамлаар орлуулдаг тийм санааг энэ ганцхан хуудас сударт бичсэн нь тун сонирхолтой. Тэгэхээр хүдрийн заарыг авах шаардлагагүй. Энэ хүний бичсэнээр бол хоёр янзаар хиймэл буюу ургамлын заар хэрэглэж болохоор байна. ДЭМБ, НҮБ-аас амьтны гаралтай түүхий эд хэрэглэхийг хориглоод байгаа. Ер нь ч ургамлаар орлуулах нь зөв, тэрийгээ тарьдаг, арчилдаг хамгаалдаг тогтолцоо руу орох ёстой юм.

Өөр нэг жишээ бол эмийн өнгөт судар 5 байна. Үнэхээр гайхамшиг гэхээс өөр яахав. Бүх амьтан, эрдэс, эмийн ургамлыг өнгөтөөр зураад, ганц хувь, гар бичмэлээр үлдээсэн. Харамсалтай нь зарим нь Монголд байхгүй. Урагшаа зарагдсан. Гэхдээ маш сайн хувийг бид авч үлдэж чадсан учраас тэртээ тэргүй монгол хүн бичсэн гэдгийг төгсгөлийн үгэнд бичсэн байгаа. Одоо судалгаанд ороод явж байна.

Манай улс соёлын өвөө хамгаалах, бүртгэх, судлах сурталчлах, өмчлөх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор 2001 онд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг Улсын их хурлаар хэлэлцүүлэн баталж, хэрэгжүүлж байна. Гэвч хуулийн 8 дугаар зүйлийн 2-т: Хувийн өмчлөлд байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг өмчлөгчийн хүсэлтийг үндэслэн бүртгэл-мэдээллийн санд бүртгэнэ гэсэн заалт хангалтгүй хэрэгжиж баримтат өвийн жагсаалтанд бүртгэгдэх ёстой хувь хүмүүст

хадгалагдаж буй монгол зохиогчтой төвөд, монгол хэлээр бичигдсэн анагаах ухааны судар ном, сурвалж бичгүүд тэдгээр дотор агуулагдаж байгаа эмчилгээний арга технологи, эмийн жорууд гадны хүмүүсийн мэдэлд орох, нэр төр, ашиг хонжооны хэрэгсэл болох, гадаадад патентлагдах боломж бүрдэж болзошгүй байна.

Дүгнэлт

Анагаахын шинжлэх ухааны түүх, сурвалж бичгийн судалгааны нэг үндсэн чиглэл бол өвчин эмгэгтэй тэмцэж ирсэн мэдлэг ухааны гол тулгуур ойлголтууд төлөвшин буй болсон бодит байдал, хөгжлийн жам ёс, үе шат, түүнд эмч, эрдэмтдийн оруулсан хувь нэмэр, судар ном, шастирын ач холбогдлыг судлан тогтоох явдал юм. Монголчууд эрт дээр үеэс нааш байгалийн юмс үзэгдлийн хувиралт, цаг уурын эрс тэс өөрчлөлтөд дасан зохицох, ахуй амьдралын онцлог, дадал хэвшил, дайн байлдаанаас үүдэлтэй гэмтэл, өвчин эмгэгийг эмчлэх аргыг амьдралын явцдаа бүтээж, үеэс үед уламжлуулан туршлагаа хуримтлуулсаар хүний биеийн бүтцийг судлах, эмчлэх, эрүүл амьдрах арга ухааны бие даасан тогтолцоог боловсруулан бий болгожээ. Энэ тогтолцоо нь зөвхөн Монгол дом засал, Энэтхэг, Төвөдийн анагаах ухааны мэдлэгт тулгуурласан бус Өрнийн анагаах ухааны сонгодог уламжлал бүхий Франц, Оросын анагаах ухаан, Манж, Хятадын анагаах ухааны эртний судар номын шимийг ч шингээн авсан мэдлэгийн цогц сан байжээ. Иймд бид мэдлэгийн энэхүү санд буй 215 судрын доторх уламжлалт анагаах ухааны зарим аргуудыг биет бус соёлын өвд бүртгүүлэх нь зүйтэй хэмээн үзэж байна.

Ном зүй

1. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, “Admon printing” ХХК, 2013, х.15-16
2. Болд Ш. Монголын анагаах ухааны түүх. Боть I. УБ, “Admon printing” ХХК, 2013
3. Bold Sh. History and Development of Traditional Mongolian Medicine. UB, 2013
4. Хатгах төөнөх тэргүүтнийг хураасан ном дэвтэр (Оршил, Б.Ринчен) УБ, 1968, х 3-5
5. Dergici toktobuha ge ti ciowan lu bithe. Манж хэлээр бичсэн гар бичмэл судар.
6. Болд Ш, Болорцэцэг Ж. Европын анагаах ухаан монголд дэлгэрсэн түүхийг тодруулах нь. Монголын анагаах ухаан. УБ, 2018 №1 (183), х.51-57
7. “Ахархан сургаал”. Хоргожин барын тод үсгийн ном